

“Инвест Монголиа-2017 Улаанбаатар”

Чуулганаас гарсан зөвлөмж бичиг

Фронтинер компани энэ оны 9 дүгээр сарын 4,5-ны өдрүүдэд уламжлал болгон зохион байгуулагддаг “Инвест Монголиа” чуулганаа Шангри-Ла Улаанбаатар зочид буудлын хурлын танхимд зохион байгууллаа. Энэ жилийн чуулганд 1100 гаруй төлөөлөгч оролцсон нь тус чуулганы түүхэнд хамгийн их оролцогч оролцсон чуулган болоод байна.

Өмнөх жилүүдийн хувьд, төрийн байгууллага болон хувийн хэвшлийн онцлох төлөөлөгчид, цаашлаад олон улсын байгууллагын мэргэжилтнүүд болон гадаадын хөрөнгө оруулагчид “Инвест Монголиа” чуулганд зочин илтгэгчээр оролцдог байсан билээ. Харин энэ жилийн хувьд Монгол Улсын Засгийн газар хамтран зохион байгуулагчаар оролцсоноор төрийн байгууллагын албан хаагчид өндөр идэвхтэйгээр оролцсон нь бусад жилүүдийнхээс онцлогтой байлаа.

Чуулганы үеэрх салбар хуралдаанууд болон илтгэлүүд дээр Монгол Улсын эдийн засаг, хувийн хэвшил болон улс төрийн нөхцөл байдлын талаар өргөн хүрээнд, илүү дэлгэрэнгүй хэлэлцлээ. Бид чуулганаас гарсан онцлох зөвлөмжүүдийг дараах 6 бүлэгт багцлаад байна:

1. **Макро эдийн засгийн бодлого**
2. **Эрх зүйт ёс, хөрөнгө оруулалтын орчин**
3. **Уул уурхайн салбарын стратеги**
4. **Эрчим хүчний салбар**
5. **Зам тээвэр, дэд бүтцийн салбар**
6. **Банк санхүүгийн салбар**

1. Макро эдийн засгийн бодлого

- Нэн тэргүүнд эдийн засгийн байдал **эрс сайжирч байгааг** дурдах нь зүйтэй. Өмнөх жилийн хувьд эдийн засгийн өсөлт **тэг хувь** байснаас гадна 2017 оны эхээр **хямрал зарлах эрсдэл** тулгараад байсан боловч 2017 оны нэгдүгээр улирлын байдлаар ДНБ-ний жилийн дүнтэй харьцуулсан өсөлт **4.2%** болсон бөгөөд, 6-р сарын сүүлээр энэ тоо **5.3%** болтлоо өссөн.
- Гэсэн хэдий ч энэ өсөлт БНХАУ-руу экспортолж буй нүүрсний экспорт өссөнтэй хамааралтай байсан тул **хэврэг өсөлт**.
- Сүүлийн 2 сарын хугацаанд зэсийн үнэ тонн тутам нь 6000 ам доллароос **6800 ам доллар** болтлоо өссөн нь бас нэгэн эерэг хүчин зүйл болсон. Мөн энэ жилийн 9-р сарын байдлаар төв банкны худалдан авсан нийт алтны хэмжээ **15.3 тонн** байгаа нь өмнөх жилийн нийт дүн болох **13.9 тонныг** даваад байна.
- Хоёр талт болон олон талт хэлэлцээрүүд мөн, АХБ-ны **500 сая ам долларын** дахин санхүүжилтийн гэрээний ачаар **Гадаад валютын нөөцийн** хэмжээ тогтмол **өсөлттэй**

байна. Гадаад валютын хэмжээ одоогийн байдлаар **1.5 тэрбум ам доллар** болоод байгаа нь оны эхний байдлаар **1.2 тэрбум ам доллар** байсантай харьцуулахад сайн үзүүлэлт юм.

- Гэсэн хэдий ч Монгол Улсын **гадаад өрийн нийт хэмжээ ДНБ-ий 218%-д хүрээд байна**. Энэ нь Монгол Улсын **зээлжих зэрэглэл доогуур үнэлгээтэй** байгаа суурь шалтгаан болж байгаа тул **төсвийн бодлогод эрс шинэчлэл хийх** зайлшгүй шаардлага тулгарч байна.
- Төсвийн бодлогын шинэтгэлийн амжилттайгаар хийж чадвал **эдийн засгийг тогтмолжуулж, сэргээхээс гадна зээлжих зэрэглэлийн үнэлгээг мөн сайжруулна**.
- **ОУВС-тай хийсэн гэрээ болон Япон, Солонгос, Энэтхэг Улс болон Дэлхийн банкт**ай байгуулах гэрээнүүд нь Монгол Улсын Засгийн газарт **өмнөх өрөө төлөх, төсвийн алдагдлаа тэнцвэржүүлэх** боломжуудыг олгож байна.
- ОУВС-гийн **эхний шатны шалгалтын дүн эерэг гарсан** нь сайшаалтай. Гэсэн хэдий ч шинэ Засгийн газар дараагийн ээлжийн санхүүжилтийг авахын тулд сүүлийн 6 сар **хэрэгжүүлсэн ажлыг үргэлжлүүлэн явуулах шаардлагатай**. Засгийн газар илүү **бодит зүйлд анхаарлаа хандуулж**, өмнөх Засгийн газруудын **гаргасан алдааг давтахгүй** байхыг эрмэлзэх хэрэгтэй.
- Засгийн газрын **нэн тэргүүнд тулгараад байгаа асуудал нь “Чингис бонд”-ын дахин санхүүжилтийн асуудал** юм. Одоогийн нөхцөл байдалд үүнийг шийдэх хамгийн сайн арга бол шинэ төрлийн бонд гаргах.
- Эрдэнэс Монгол, МИАТ, Улаанбаатарын цахилгаан станц зэрэг төрийн өмчийн аж ахуй нэгжүүдийг **шат дараатайгаар хувьчлах** нь нэг талаас Засгийн газрын **өрийн хэмжээг буруулах**, нөгөө талаас тус аж ахуй нэгжүүдийн **өрсөлдөх чадварыг дээшлүүлэх** давхар ач холбогдолтой.
- Аж ахуй нэгжүүдийн **ил тод байдал болон эгэх хариуцлагыг сайжруулах нь** нэн ялангуяа **төрийн өмчийн ахуй үнэлэмжийг нэмэгдүүлэхэд** чухал ач холбогдолтой.
- **Улс төрийн тогтворгүй байдал** нь хөрөнгө оруулагчдын **хамгийн чухал анхаарал хандуулсан асуудал** болоод байна. Засгийн газар өөрчлөгдөж болох боловч **хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээнүүд өөрчлөгдөх ёсгүй**.
- Засгийн газар **тэргүүлэх чиглэлийн бодлогуудаа** нэн яаралтай тодорхойлж, үйл ажиллагааны хөтөлбөрөө чандлан биелүүлэх хэрэгтэй. Ялангуяа, **дэд бүтцийн салбарт хэрэгжүүлэх урт хугацааны зураглалаа** тодорхой болгох шаардлагатай байна.
- Урт хугацааны бодлогодоо **түүхийн эдийн үнийн савлагаанаас хэт хамааралтай** байдлыг багасгах тал дээр дорвитой шийдлүүдийг тусгах нь зүйтэй. Монгол Улс уул уурхайн бус салбарууд болох **хөдөө аж ахуй, банк санхүү, аялал жуулчлал, эрчим хүч** болон **технологийн салбаруудад анхаарлаа хандуулж, эдийн засгаа солонгоруулах** шаардлагатай.
- Хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд төрийн зүгээс аль болох **бага оролцох** хэрэгтэй
- Хөдөө аж ахуйн салбарын хувьд, **БНХАУ болон Европын холбооны улсууд** бүтээгдэхүүнээ нийлүүлэх хамгийн боломжит зах зээлүүд болоод байна. Европын

болон урд хөршийн хэрэглэгчид **өндөр чанартай, органик хүнсийг** хэрэглэхийг эрхэмлэдэг болоод байгаа нь Монгол Улсын хувьд таатай боломжийг нээж өгч байна. Хамгийн гол нь **Олон улсын чанарын стандартад нийцсэн** бүтээгдэхүүн үйлдвэрлэх тал дээр анхаарал хандуулах шаардлагатай. Энэ асуудалд мэдээж Засгийн газрын дэмжлэг хэрэгтэй.

- **Технологийн бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэх, оюун ухааны нөөц боломжоо ашиглах** нь Монголын эдийн засгийг сэргээх томоохон хүчин зүйл болох боломжтой. Монгол Улсад олон тооны авьяаслаг залуу инженерүүд бий. Тиймээс **хөрөнгө оруулалтын орчноо** сайжруулах замаар тэдгээр залуучуудад хөрөнгө оруулалт хийвэл үр дүнтэй.
- Монгол Улс **газар зүйн байрлалын хувьд дата, мэдээлэл цуглуулах, дамжуулах** болон бусад төрлийн **технологийн үйлчилгээ эрхлэх** нэн тохиромжтой бүсэд байрладаг. Эдгээрт тохирсон **журам, зохицуулалтуудыг** нэн яаралтай бий болгох хэрэгтэй.

2. Эрх зүйт ёс, хөрөнгө оруулалтын орчин

- **Эрх зүйт ёсыг чандлан мөрдөх**, ялангуяа байгуулсан гэрээгээ биелүүлэх нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын итгэлийг сэргээхэд чухал ач холбогдолтой
- Хууль, эрх зүйн хүрээнд **гэнэтийн өөрчлөлтөөс сэргийлсэн хууль** боловсруулж, хэрэгжүүлэх нь чухал үр дүнтэй.
- 2009 оны Оюун толгойн гэрээнд өөрчлөлт оруулсан нь хөрөнгө оруулалтын **итгэлийг үлэмж хэмжээгээр бууруулсан. Тодорхой, тогтвортой, ил тод байдал** нь хөрөнгө оруулалтын орчинг сайжруулахад чухал нөлөөтэй. Засгийн газар шинээр байгуулагдах бүрдээ 2009 онд байгуулсан Оюу толгойн үндсэн гэрээг өөрчилнө гэж ярьдаг нь хүлээн зөвшөөрөх боломжгүй асуудал.
- 2017 оны 3 дугаар сард **Хөрөнгө Оруулалтын Эрх Ашгийг Хамгаалах Зөвлөлийг** байгуулсан явдал нь маш **сайшаалтай алхам** байлаа. Энэ явдал нь өмнөх Засгийн газрын хийж гүйцэтгэсэн хамгийн их ололттой ажлуудын нэг байсан. Шинэ Засгийн газар энэ ажлыг **үргэлжлүүлэн**, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах тал дээр **идэвх чармайлттай** ажиллана хэмээн найдаж байна.
- Тус Зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх нь чухал асуудал юм. Тодруулбал, **мэдээлэл технологийн шинэлэг хэрэгслүүдийн** тусламжтайгаар хөрөнгө оруулагчдын гомдол саналыг **тодорхой цаг хугацааны дарааллаар** хүлээн авч, **эгэх хариуцлагатайгаар шийддэг нэгдсэн системийг** бий болгох нь чухал. Ийм төрлийн мэдээл технологийн хэрэгсэл нь **хөрөнгө оруулалтын орчны асуудал**, тэдгээрийн **чиг хандлагад дүн шинжилгээ хийх** зориулалт бүхий **мэдээллийн хангамжийг** бий болгоход чухал ач холбогдолтой. Энэ нь мөн Засгийн газар богино хугацаанд солигдсоор байгаа ийм үед **тогтмол бодлого хэрэгжүүлэхэд ач тустай**.
- Хөрөнгө оруулагчдын зүгээс төрийн байгууллагын буруутай үйл ажиллагаа тэдний эрхэнд халдаж байна хэмээн гомдол гаргасан үед **Төр, хувийн хэвшил нэг дор цуглан асуудлаа зөвшилцдөг сувгийг** үүсгэн байгуулж, Хөрөнгө оруулалтын эрх

ашгийг хамгаалах зөвлөл энэ уулзалтад **хөрөнгө оруулагчдын талд зогсдог** болбол **аюулгүйн баталгаа** улам бүр сайжирч, улмаар хөрөнгө оруулалтын итгэл сайжирна.

- Монгол Улсад олон жил ажилласан **туршлагатай хөрөнгө оруулагчид** цаашдын ирээдүйд **эргэлзсэн хэвээр** байна. Тэдний ихэнх нь **чанартай, тогтвортой** бөгөөд **тодорхой дүрэм журмуудыг** яаралтай бий болгохгүй бол өөр орон луу хөрөнгө оруулалт хийх болно хэмээн ярьж эхлээд байна. Засгийн газрын хөрөнгө оруулалтыг хамгаалах тал дээр хийж буй хүчин чармайлтын **бодит илрэл** нь дээр дурдсан **механизмыг бий болгох**. Энэ систем бий болтол ихэнх улсын ЭСЯ-дууд өөрийн орны хөрөнгө оруулагчдад хандан сэрэмжтэй байхыг зөвлөн, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг анхааралтай ажсан хүлээлтийн байдалтай байна.
- Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулагчид болон тэдний төлөөлөгчид арилжааны маргаантай холбоотойгоор эрүүгийн хэргээр шүүхэд татагдсан харамсалтай жишээнүүд байна. Сүүлийн жилүүдэд энэ төрлийн хэд хэдэн харамсалтай хэргүүд гарсны дотор **Хаан Ресурс** болон **Саут Гоби**-той холбоотой хэрэг гадаадын хөрөнгө оруулалтыг чөдөрлөсөн томоохон хэргүүдийн нэг болсон. Салбар хуралдааны илтгэгчдийн нэг маань: **“Хөрөнгө оруулалт хийчхээд эцэстээ өөрөө шоронд орох юм бол хэн энэ улсад хөрөнгө оруулахаар ирэх вэ?”** хэмээн хурцаар шүүмжилж байлаа.
- Гадаадын хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах тал дээр учир дутагдалтай, мөн эрүүгийн хэрэгт татагдах эрсдэл өндөр байгаа нь хууль эрх зүйн хувьд хамгийн бэрхшээлтэй асуудлууд болоод байна. Ийм төрлийн хэргүүд гарах болгонд гадаадын хөрөнгө оруулагчдын дунд Монгол Улсын нэр хүнд улам бүр унасаар байна.
- Харамсалтай нь, дээр дурдсан **түр зуурын эдийн засгийн өсөлт** болон, **хууль эрх зүйн орчны өнгөн талын засвар, шинэчлэлүүд** нь гадаадын хөрөнгө оруулагчдад хангалттай **итгэл төрүүлж чадахгүй** байна. Мэдээж, Ерөнхий сайд болон түүний Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулсан явдал нь гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг үлэмж хэмжээгээр бууруулсан ч илүү чадвартай, мэргэжлийн туршлагатай гишүүд Засгийн газрын гишүүнээр томилогдсон явдал нь гадаадын хөрөнгө оруулагчдад тааламжтай байна.

3. Уул уурхайн салбарын стратеги

- Уул уурхайн салбар нь Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн хөгжлийг тодорхойлох **хамгийн чухал салбар**. Түүхий эдийн **алтан үе** өнгөрсөн ч Монгол Улс нөөц ихтэй олон төрлийн түүхий эдийн хувьд урт хугацааны эрэлт байсаар байх төлөвтэй байна.
- Бизнесийн итгэлээ сайжруулахын тулд гадны орнуудаас тусламж, дэмжлэг эрэлхийлэхийн оронд, дотоодын нөөц бололцоогоо ашиглан **хууль эрх зүйн орчноо сайжруулах, өндөр чанарын хөрөнгө оруулалт татах орчинг бүрдүүлэх** зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай байна.
- **Си Ар Ю Группын судалгаагаар, зэс** болон бусад төрлийн **үндсэн металлуудын үнэ** ойрын хэдэн жилдээ **тогтвортой өсөх** төлөвтэй байна. Гэвч экспортын ашгийг

хамгийн өндөр төвшинд хүргэхийн тулд, **өрсөлдөх чадвартай**, бөгөөд **зохицуулалт сайтай дэд бүтцийг** бий болгох шаардлагатай.

- Засгийн газрын зүгээс уул уурхайн **олборлолтын төслүүдэд** хандаж ил тод бөгөөд **эгэх хариуцлага** бүхий бодлого баримтлах шаардлагатай. Уул уурхайн олборлолтын байдлыг хаанаас ч харж болох нээлттэй **нэгдсэн системийг** бий болгох шаардлагатай.
- Мөн **татварын тогтвортой бодлого** болон, **роялти систем** бий болгох нь энэ салбарын цаашдын хөгжилд томоохон ач холбогдолтой.
- Засгийн газар хамгийн их анхаарал татаж уул уурхайн төслүүдийг **дэс дараатайгаар эрэмбэлэн, үе шаттайгаар хэрэгжүүлэх** хэрэгтэй. Өнөөгийн байдлаар **Оюу толгой, Таван толгой** болон **Гацуурт** төслүүдэд анхаарал хандуулан ажиллах нь зүйтэй.
- Одоо байгаа уул уурхайн төслүүдийг **өгөөж гаргадаг болгох** нь **нэн тэргүүний асуудал** юм. Ингэснээр олон төрлийн үр ашиггүй зардлуудаас сэргийлэх боломжтой.
- Уул уурхайн салбарын урт хугацааны хөгжлийг бэхжүүлэх, мөн **өндөр ашиг бүхий уул уурхайн үйлчилгээг** бий болгоход **хүний нөөцийн хөгжил** чухал ач холбогдолтой. Тухайлбал, Австрали Улсын жишээг харахад, тэдний сүүлийн 40 жилийн туршид бий болгосон мэргэжлийн өндөр түвшний уул уурхайн үйлчилгээ нь салбарын ашгийг нэмэгдүүлэхээс гадна, гадны хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээр татаж байна.
- Монгол Улсын уул уурхайн салбарын хөгжлийн бас нэгэн шийдэл нь олон тооны **өрсөлдөх чадвар сайтай олборлолтын компаниудыг бий болгох** юм. Эдгээр компаниудын тусламжтайгаар **ирээдүйд олон тооны чанартай төслүүдийг хэрэгжүүлж чадна.**

4. Эрчим хүчний салбар

- **Монгол Улс нь эрчим хүчний арвин их нөөцтэй улс.** Зөвхөн нүүрсний нөөцөөр зогсохгүй, **нарны болон салхины эрчим хүчний** асар их нөөцтэй. Эрчим хүчний салбар нь эдийн засагт урт хугацаанд үзүүлэх үр нөлөөгөөрөө уул уурхайн салбарын дараа **хоёр дугаарт** орно. Гэсэн хэдий ч өнөөгийн байдлаар Монгол Улс хэрэглээний эрчим хүчний **20% гаруй хувийг** ОХУ болон БНХАУ-аас **импортолж** байна. БНХАУ, Япон, Солонгос зэрэг улсууд Монгол Улсаас эрчим хүч импортлох сонирхлоо илэрхийлээд байгаа энэ үед Монгол Улс энэ салбарын **гол тоглогч** болох боломжтой.
- Монгол Улсын Засгийн газар эрчим хүчний салбар, ялангуяа **нөхөн сэргээгдэх эрчим хүчний салбарт** баримтлах **урт хугацааны хөгжлийн бодлогоо** тодорхойлох шаардлагатай. Дэлхийн банк Монгол Улс салхины болон нарны хүчийг ашиглан **жил бүр 2.5 Гига Ватт эрчим хүч** үйлдвэрлэх боломжтой хэмээн үнэлсэн байна. Бас нэгэн судалгаагаар Монгол Улс нь **хамгийн бага зардлаар** нөхөн сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх боломжтой улсаар тодорсон.
- Сүүлийн жилүүдэд **маш олон тооны** эрчим хүчний төслүүдийн талаар ярьсан. Харамсалтай нь, **тун цөөхөн** нь бодитойгоор хэрэгжиж эхлээд байна. Иймээс Засгийн газар эрчим хүчтэй холбоотой төслүүдээ үр өгөөжийн чанарын дагуу **эрэмбэлэн,**

эрчим хүчний салбарт баримтлах урт хугацааны хөгжлийн бодлоготойгоо уялдуулан хэрэгжүүлэх хэрэгтэй.

- Засгийн газар эрчим хүчний зардлыг бууруулах ажилд технологийн инновацийг аль болох нэвтрүүлж, нөхөн сэргээгдэх эрчим хүчний хэрэглээнд хөнгөлөлт олгох гэх мэтийн урамшууллын ажлуудыг санаачлан хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Улаанбаатар хотод хэрэгжүүлж болох сэргээгдэх эрчим хүчний бас нэгэн сонирхолтой шийдэл нь “Дээвэр дээрх нарны эрчим хүч” төсөл юм. Нарны эрчим хүчний зардал сүүлийн 5 жилийн дотор 90% гаруй хувиар буураад байна. “Свансоны хууль”-ийн тусламжтайгаар энэ тоо ирэх жилүүдэд улам бүр буурах төлөвтэй байна. Тиймээс энэ төрлийн шийдэл нь Улаанбаатар хотын эрчим хүчний болон агаарын бохирдлын асуудлыг урт хугацаанд шийдэх боломжтой.

5.Зам тээвэр, дэд бүтэц

- Үр ашигтай зам тээвэр, дэд бүтцийн хомсдолтой байдал нь Монгол Улсыг уул уурхайн салбарт ашигтай ажиллаж, уул уурхайн орлогыг хамгийн өндөр төвшинд байлгах явдалд саад учруулсаар байна. Энэ асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Тухайлбал, Австралийн уул уурхайтай харьцуулахад, олборлолтын зардал харьцангуй өрсөлдөхүйц хэмжээний боловч, тээвэрлэлтийн зардал хэд дахин өндөр байна.
- Сүүлийн арван жилд олон тооны авто замын болон төмөр замын төслүүдийн талаар ярьсан боловч цөөн тооны төсөл бодитоор хэрэгжсэн. Тиймээс Засгийн газар хэрэгжихэд бэлэн болсон бодит төслүүдийг яаралтай урагшлуулах шаардлагатай.
- БНХАУ-ын “Нэг бүс, нэг зам” санаачилга нь Монгол Улсыг бусад улсуудтай зам тээвэр, дэд бүтцээр холбох өргөн боломжуудыг олгож байна. Өнөөгийн байдлаар, “Нэг бүс, нэг зам” хөтөлбөрт хамрагдаж буй улсууд дэлхийн нийт худалдааны 40% гаруй хувийг бүрдүүлж байна. “Төв Азийн Бүс Нутгийн Эдийн Засгийн Хамтрал” дэд бүтцийг хөгжүүлэх стратегийн хүрээнд ирэх 5 жилийн дотор 18 тэрбум ам доллар бүхий 8 том төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Тиймээс Монгол Улс “Нэг бүс, нэг зам” хөтөлбөрийн гол тоглогч болохын тулд өөрсдийгөө сайн бэлдэн, шаардлагатай арга хэмжээнүүдийг авч эхлэх нь үр дүнтэй.

6. Банк санхүүгийн салбар

- Бат бөх, найдвартай банкны систем, зөв бүтэцтэй хөрөнгийн зах зээлийг бий болгох нь Монгол Улсын эдийн засгийг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх тулгуур болно.
- 9-р сарын байдлаар, банкны систем дахь чанаргүй зээл болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ нийт зээлийн багцын 16%-тай тэнцэж байгаа нь өмнөх жилийнхтэй адил үзүүлэлт.
- ОУВС-гийн хөтөлбөр, түүнийг дагалдах Активын чанарын үнэлгээ нь дотоодын аж ахуй нэгжүүд бодит үнэлгээнээсээ дутуу үнэлэгддэг асуудлыг шийдвэрлэхээс гадна

гадаад хөрөнгөө дотогш татах боломжийг бүрдүүлж байна. Мөн, арилжааны банкууд дотоодын болон гадны хөрөнгийн биржид **хувьцаа гаргахад** түлхэц үзүүлнэ.

- Дор хаяж нэг, цаашлаад олон тооны банкуудыг МХБ-д хувьцаа гаргуулах нь дотоодын хөрөнгийн зах зээлийг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна. МХБ дээр арилжаалагдаж буй хувьцаануудын нийт үнэлгээ нь 2 их наяд төгрөг буюу ДНБ-ний 10%-д хүрэхгүй байна. Бусад улсуудын хөрөнгийн зах зээлийн хувьд энэ тоо ихэвчлэн ойролцоогоор 1:1 байдаг.
- Засгийн газар хувьцаа эзэмшигчдэд **урамшуулал олгох**, тэтгэврийн сангуудын нийт активын дор хаяж **гуравны нэгтэй тэнцэх** хөрөнгийг **Хөрөнгийн зах зээлд байршуулах** зэрэг ажлуудыг хэрэгжүүлж эхэлбэл хөрөнгийн зах зээл сэргэхээс гадна, Монгол компаниудыг Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаа гаргахад түлхэц болно.
- **Үр ашигтай хөрөнгийн зах зээлийг** бий болгосон нөхцөлд л дотоодын аж ахуй нэгжүүд **зардал багатайгаар санхүүжилт татаж чадна**. Энэ нь мөн, урт хугацаанд зээлийн хүүг бууруулж, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтөд чухал ач холбогдолтой.

- оОо -